



I-IV/2022

Тархаасан: 2022 оны 6 дугаар сарын 13




Нийтийн хоолны салбарын орлого өмнөх сараас 11.4 хувиар өсжээ

Нийтийн хоолны салбарын орлого 2022 оны эхний 4 сард 287.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 123.1 тэрбум төгрөг буюу 74.8 хувиар өсжээ. Үүнд рестораны орлого өмнөх оны мөн үеэс 95.9 (2.1 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийтийн хоолны салбарын орлого 2022 оны 4 дүгээр сард 88.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 9.1 (11.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 1. НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ОРЛОГО, төрлөөр, тэрбум төгрөг, жил бүрийн эхний 4 сарын байдлаар



Рестораны орлогын эзлэх хувь 2022 оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс 11.2 нэгж хувь, баарных 2.1 нэгж хувь, кафеных 0.4 нэгж хувиар тус тус өсөж, харин захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлогын эзлэх хувь 12.1 нэгж хувь, гуанзных 1.6 нэгж хувиар тус тус буурсан байна.


Зочид буудлын салбарын орлого өмнөх сараас 5.7 хувиар буурчээ

Зочид буудлын салбарын орлого 2022 оны эхний 4 сард 99.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 46.0 (86.9%) тэрбум төгрөгөөр өсжээ. Үүнд 3 ба түүнээс дээш одтой буудлын орлого 31.6 (89.3 %) тэрбум төгрөг, зэрэглэлгүй зочид буудал болон амралтын газрын орлого 13.1 (79.4%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зочид буудлын салбарын орлого 2022 оны 4 дүгээр сард 27.3 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.7 (5.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд 3 ба түүнээс дээш одтой буудлын орлого 453.4 (12.8%) сая төгрөг, зэрэглэлгүй зочид буудлын орлого 1.3 (13.4%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Зочид буудлын салбарын 2022 оны эхний 4 сарын нийт орлогын 67.7 хувийг 3, түүнээс дээш одтой зочид буудал, 29.9 хувийг зэрэглэлгүй зочид буудал, амралтын газар, 2.4 хувийг 2 одтой зочид буудлын орлого тус тус эзэлж байна.

ЗУРАГ 2. ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ОРЛОГО, ЗЭРЭГЛЭЛЭЭР, тэрбум төгрөг, жил бүрийн эхний 4 сарын байдлаар



Ойлголт, тодорхойлолт:

Нийтийн хоолны салбарт ресторан, кафе, баар, гуанз, захиалгат хоол хүргэх, үйлчлэх үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг хамруулна. Зочид буудлын үйл ажиллагаанд зочид буудал, амралтын газар, хүүхдийн зуслан, түр хоноглох байруудын үйл ажиллагаа хамрагдана.



Эх үүсвэр:

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан

Ангилал, код:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал.

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ гархаах хуваарь:

2022 оны 7 дугаар сарын 19

Эдийн засгийн статистикийн газрын дарга А.Дэмбэрэл
Утас : (976-51)-329271

Эдийн засгийн статистикийн газрын статистикч Ч.Мөнхтуул
Утас : (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212